

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Татварын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2026/009/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Говьсүмбэр аймаг 2026 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Аудитор: С.Батцэцэг Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу..

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ТАТВАРЫН ГАЗРЫН ТӨСВИЙН
ШУУД ЗАХИРАГЧ П.ЭНХ-ОЮУН
ТАНАА

2026.02.11 № 03
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Татварын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4226050040

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 83.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		32,092,439.11	22,927,133.11
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		7,347,554.58	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		7,347,554.58	0.00
3121	Төгрөг		7,347,554.58	0.00
31211	Төрийн сангийн харилцах		7,347,554.58	0.00
33	АВЛАГА		0.00	320,095.58
335	Бусад авлага		0.00	320,095.58
3351	Байгууллагаас авах авлага		0.00	320,095.58
35	БАРАА МАТЕРИАЛ		24,744,884.53	22,607,037.53
354	Хангамжийн материал		24,744,884.53	22,607,037.53
35410	Бичиг хэргийн материал		2,911,416.12	1,877,216.12
35420	Аж ахуйн материал		19,992,218.41	19,642,221.41
35430	Сэлбэг хэрэгсэл		413,650.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал		340,000.00	0.00
35470	Бусад хангамжийн материал		1,087,600.00	1,087,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		733,066,012.00	701,779,927.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		733,066,012.00	701,779,927.38
392	Биет хөрөнгө		728,381,977.40	697,170,767.98
39201	Барилга, байгууламж, орон сууц		733,592,744.00	733,592,744.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		-74,038,824.00	-89,395,444.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл		66,900,000.00	66,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		-56,065,368.59	-66,900,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)		90,954,019.03	101,840,410.66
39206	Хуримтлагдсан элэгдэл		-66,404,451.08	-76,177,256.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		52,207,400.00	52,207,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		-18,763,541.96	-24,897,085.44
393	Биет бус хөрөнгө		4,684,034.60	4,609,159.40
39303	Бусад биет бус хөрөнгө		6,474,901.50	6,474,901.50
39304	Хуримтлагдсан элэгдэл		-1,790,866.90	-1,865,742.10
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		765,158,451.11	724,707,060.49
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		0.00	365,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		0.00	365,000.00
413	Өглөг		0.00	365,000.00
4136	Бусад өглөг		0.00	365,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг		0.00	365,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		765,158,451.11	724,342,060.49
51	Засгийн газрын хувь оролцоо		765,158,451.11	724,342,060.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		103,002,637.26	103,002,637.26
51101	Өмч: - төрийн		103,002,637.26	103,002,637.26
512	Хуримтлагдсан үр дүн		661,470,903.87	620,654,513.25
51210	Өмнөх үеийн үр дүн		624,538,198.75	661,470,903.87
51220	Тайлант үеийн үр дүн		36,932,705.12	-40,816,390.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		684,909.98	684,909.98
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		765,158,451.11	724,707,060.49

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		753,219,335.80	627,337,847.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		82,585,335.80	11,001,714.63
120	Нийтлэг татварын бус орлого		82,585,335.80	11,001,714.63
120009	Бусад орлого		7,208,255.00	115,320.00
120010	Үнэ төлбөргүй авсан хүлээн авсан орлого		75,377,080.80	10,886,394.63
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		670,634,000.00	616,336,132.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		631,909,000.00	584,320,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		631,909,000.00	584,320,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		38,725,000.00	32,015,332.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		38,725,000.00	32,015,332.50
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		716,286,630.68	668,154,237.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ		716,286,630.68	668,154,237.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		659,941,345.61	599,046,247.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		433,950,917.91	381,019,052.77
210101	Үндсэн цалин		193,232,128.16	188,259,185.72
210102	Нэмэгдэл		120,353,125.19	111,728,344.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт		21,492,200.00	23,451,238.56
210104	Урамшуулал		98,873,464.56	57,580,284.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		53,111,928.15	50,055,687.32
210201	Тэтгэврийн даатгал		36,342,951.94	33,923,077.89
210202	Тэтгэмжийн даатгал		4,273,001.43	3,990,950.35
210203	ҮОМШ өвчний даатгал		2,158,012.77	3,087,175.17
210204	Ажилгүйдлийн даатгал		2,077,310.86	1,810,896.79
210205	Эрүүл мэндийн даатгал		8,260,651.15	7,243,587.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		83,492,635.95	84,784,492.23
210301	Гэрэл цахилгаан		1,790,271.27	2,063,357.98
210302	Түлш, халаалт		39,377,184.00	39,377,184.00
210303	Цэвэр, бохир ус		604,414.00	1,171,474.00
210305	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал		41,720,766.68	42,172,476.25
2104	Хангамж, бараа материалын зардал		13,287,985.60	8,246,511.00
210401	Бичиг хэрэг		4,537,000.00	2,559,740.00
210402	Тээвэр, шатахуун		3,910,000.00	340,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр		3,242,771.60	3,938,211.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,178,200.00	1,166,800.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		180,014.00	1,760.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,887,000.00	1,386,050.00
210604	Урсгал засвар		1,887,000.00	1,386,050.00

2107	Томилолт, зочны зардал		4,550,000.00	4,434,000.00
210702	Дотоод албан томилолт		4,550,000.00	4,434,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		59,511,178.00	60,503,064.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		57,573,000.00	60,434,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,062,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ		840,100.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		0.00	42,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр		14,078.00	4,464.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		10,149,700.00	8,617,390.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		8,703,500.00	7,337,390.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,446,200.00	1,280,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		56,345,285.07	69,107,990.43
2132	Бусад урсгал шилжүүлэг		20,223,986.00	12,138,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		18,903,986.00	9,234,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,320,000.00	2,904,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		36,121,299.07	56,969,990.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		36,121,299.07	56,969,990.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		36,932,705.12	-40,816,390.62
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		36,932,705.12	-40,816,390.62

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		0.00	0.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		677,842,255.00	616,451,452.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		7,208,255.00	115,320.00
120	Нийтлэг татварын бус орлого		7,208,255.00	115,320.00
120009	Бусад орлого		7,208,255.00	115,320.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		670,634,000.00	616,336,132.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		631,909,000.00	584,320,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		631,909,000.00	584,320,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		38,725,000.00	32,015,332.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		38,725,000.00	32,015,332.50
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)		679,372,500.00	623,799,007.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ		679,372,500.00	623,799,007.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		623,027,214.93	554,565,532.07
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		433,950,917.91	382,374,663.77
210101	Үндсэн цалин		193,232,128.16	189,234,773.79
210102	Нэмэгдэл		120,353,125.19	117,716,635.41

210103	Унаа хоолны Хөнгөлөлт		21,492,200.00	18,181,011.84
210104	Урамшуулал		98,873,464.56	57,242,242.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		53,111,928.15	48,894,687.32
210201	Тэтгэврийн даатгал		36,342,951.97	33,923,077.89
210202	Тэтгэмжийн даатгал		4,273,001.40	3,990,950.35
210203	ҮОМШӨ-ний даатгал		2,158,012.77	1,926,175.17
210204	Ажилгүйдлийн даатгал		2,077,310.86	1,810,896.79
210205	Эрүүл мэндийн даатгал		8,260,651.15	7,243,587.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		41,771,869.27	42,612,015.98
210301	Гэрэл, цахилгаан		1,790,271.27	2,063,357.98
210302	Түлш, халаалт		39,377,184.00	39,377,184.00
210303	Цэвэр, бохир ус		604,414.00	1,171,474.00
2104	Хангамж, бараа материалын зардал		15,274,971.60	6,149,011.00
210401	Бичиг хэрэг		4,335,000.00	902,300.00
210402	Тээвэр, шатахуун		4,150,000.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		3,242,771.60	3,938,211.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,307,200.00	1,068,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,300,650.00	875,700.00
210604	Урсгал засвар		2,300,650.00	875,700.00
2107	Томилолт, зочны зардал		4,550,000.00	4,434,000.00
210702	Дотоод албан томилолт		4,550,000.00	4,434,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		59,511,178.00	60,138,064.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		57,573,000.00	60,069,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,062,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ		840,100.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		0.00	42,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр		14,078.00	4,464.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		12,555,700.00	9,087,390.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		8,703,500.00	7,337,390.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		3,852,200.00	1,750,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		56,345,285.07	69,233,475.01
2132	Бусад урсгал шилжүүлэг		20,223,986.00	12,138,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтэй ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		18,903,986.00	9,234,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,320,000.00	2,904,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		36,121,299.07	57,095,475.01
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		36,121,299.07	57,095,475.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		-1,530,245.00	-7,347,554.58

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		-1,530,245.00	-7,347,554.58
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		8,877,799.58	7,347,554.58
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		7,347,554.58	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
4-01	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	103,002,637.26	684,909.98	624,538,198.75	728,225,745.99
4-02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	103,002,637.26	684,909.98	624,538,198.75	728,225,745.99
4-04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
4-05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
4-08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	36,932,705.12	36,932,705.12
4-01	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	103,002,637.26	684,909.98	661,470,903.87	765,158,451.11
4-02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	103,002,637.26	684,909.98	661,470,903.87	765,158,451.11
4-07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
4-08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-40,816,390.62	-40,816,390.62
4-01	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	103,002,637.26	684,909.98	620,654,513.25	724,342,060.49

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Бүртгэлийн дансны код	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		599,936,200.00	527,767,848.87	72,168,351.13	87.97
УРСГАЛ ЗАРДАЛ		599,936,200.00	527,767,848.87	72,168,351.13	87.97
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		587,798,200.00	515,629,848.87	72,168,351.13	87.72
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		407,864,400.00	354,241,767.77	53,622,632.23	86.85
Үндсэн цалин	21010100	187,687,100.00	189,234,773.79	-1,547,673.79	100.82
Нэмэгдэл	21010400	98,711,900.00	89,583,739.41	9,128,160.59	90.75
Унаа хоолны Хөнгөлөлт	21010300	25,689,200.00	18,181,011.84	7,508,188.16	70.77
Урамшуулал	21010400	95,776,200.00	57,242,242.73	38,533,957.27	59.77

Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		51,916,600.00	45,429,290.12	6,487,309.88	87.50
Тэтгэврийн даатгал	21020100	35,542,200.00	31,531,781.76	4,010,418.24	88.72
Тэтгэмжийн даатгал	21020200	4,100,800.00	3,709,621.39	391,178.61	90.46
ҮОМШӨ-ний даатгал	21020300	2,048,800.00	1,785,510.70	263,289.30	87.15
Ажилгүйдлийн даатгал	21020400	2,045,000.00	1,680,475.27	364,524.73	82.17
Эрүүл мэндийн даатгал	21020500	8,179,800.00	6,721,901.00	1,457,899.00	82.18
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		44,083,900.00	42,612,015.98	1,471,884.02	96.66
Гэрэл, цахилгаан	21030100	2,394,400.00	2,063,357.98	331,042.02	86.17
Түлш, халаалт	21030200	39,377,400.00	39,377,184.00	216.00	100.00
Цэвэр, бохир ус	21030300	2,312,100.00	1,171,474.00	1,140,626.00	50.67
Хангамж, бараа материалын зардал		9,766,700.00	6,149,011.00	3,617,689.00	62.96
Бичиг хэрэг	21040100	1,676,400.00	902,300.00	774,100.00	53.82
Тээвэр, шатахуун	21040200	1,000,000.00	0.00	1,000,000.00	0.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21040300	3,861,300.00	3,938,211.00	-76,911.00	101.99
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	21040500	239,400.00	240,000.00	-600.00	100.25
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21040600	2,989,600.00	1,068,500.00	1,921,100.00	35.74
Эд хогшил, урсгал засварын зардал		906,400.00	875,700.00	30,700.00	96.61
Урсгал засвар	21060400	906,400.00	875,700.00	30,700.00	96.61
Томилолт, зочны зардал		8,633,100.00	4,434,000.00	4,199,100.00	51.36
Дотоод албан томилолт	21070200	8,633,100.00	4,434,000.00	4,199,100.00	51.36
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		63,347,100.00	60,138,064.00	3,209,036.00	94.93
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21080100	60,538,800.00	60,069,100.00	469,700.00	99.22
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	21080200	1,075,100.00	0.00	1,075,100.00	0.00
Даатгалын үйлчилгээ	21080300	1,354,000.00	0.00	1,354,000.00	0.00
Тээврийн хэрэгслийн татвар	21080400	42,500.00	42,500.00	0.00	100.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	21080500	22,000.00	22,000.00	0.00	100.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21080600	309,900.00	0.00	309,900.00	0.00
Газрын төлбөр	21080700	4,800.00	4,464.00	336.00	93.00
Бараа үйлчилгээний бусад зардал		1,280,000.00	1,750,000.00	-470,000.00	136.72
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	21090200	1,280,000.00	1,750,000.00	-470,000.00	136.72
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		12,138,000.00	12,138,000.00	0.00	100.00
Бусад урсгал шилжүүлэг		12,138,000.00	12,138,000.00	0.00	100.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21320800	9,234,000.00	9,234,000.00	0.00	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21320900	2,904,000.00	2,904,000.00	0.00	100.00

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		599,936,200.00	527,767,848.87	72,168,351.13	87.97
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		599,936,200.00	527,767,848.87	72,168,351.13	87.97
Улсын төсвөөс санхүүжих	13100100	599,936,200.00	527,767,848.87	72,168,351.13	87.97
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00	0.00	0.00	0.00
АЖИЛЛАГСАДЫН ТОО		14.00	9.00	5.00	0.00
Удирдах ажилтан		1.00	1.00	0.00	
Гүйцэтгэх ажилтан		10.00	5.00	5.00	
Үйлчилгээний ажилтан		3.00	3.00	0.00	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Бүртгэлийн дансны код	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		32,015,332.00	32,015,332.00	0.00	100.00
УРСГАЛ ЗАРДАЛ		32,015,332.00	32,015,332.00	0.00	100.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		32,015,332.00	32,015,332.00	0.00	100.00
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		32,015,332.00	32,015,332.00	0.00	100.00
Үндсэн цалин	21010100	0.00	0.00	0.00	
Нэмэгдэл	21010200	28,286,227.00	28,286,227.00	0.00	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		3,729,105.00	3,729,105.00	0.00	100.00
Тэтгэврийн даатгал	21020100	2,482,067.00	2,482,067.00	0.00	100.00
Тэтгэмжийн даатгал	21020200	312,952.00	312,952.00	0.00	100.00
ҮОМШӨ-ний даатгал	21020300	156,476.00	156,476.00	0.00	100.00
Ажилгүйдлийн даатгал	21020400	155,522.00	155,522.00	0.00	100.00
Эрүүл мэндийн даатгал	21020500	622,088.00	622,088.00	0.00	100.00
Хангамж бараа материйлын зардал		0.00	0.00	0.00	#DIV/0!
Бичиг хэрэг	210401000	0.00	0.00	0.00	0.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		32,015,332.00	32,015,332.00	0.00	100.00
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		32,015,332.00	32,015,332.00	0.00	100.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	13100100	32,015,332.00	32,015,332.00	0.00	100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00	0.00	0.00	0.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Завсрын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Тус байгууллагад 2025 оны 3 дугаар улирлын байдлаар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд завсрын аудит гүйцэтгэж, нийт 8 горим сорилыг хэрэгжүүлж, асуудлын бүртгэлээр 15,390.7 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илэрснээс 12,154.7 мянган төгрөгийн 7 алдааг залруулах, 3,236.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн байна. Нийт 12,154.7 мянган төгрөгийн 7 алдааг залруулж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Аудитаар нийт 12,294.3 мянган төгрөгийн 8 алдаа¹ илэрснээс завсрын аудитаар 12,154.7 мянган төгрөгийн 7, аудитын явцад 139.6 мянган төгрөгийн 1 алдааг тус тус залруулсан байна

Залруулсан алдаа:

1. Авлага үүсгэхдээ цалингийн зардлыг 589.4 мянган төгрөгөөр бууруулж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” заалтуудтай нийцээгүй.
2. Шуудан холбооны зардлаас 220.0 мянган төгрөгийн өглөгийг хааж бичилт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах”, 16 дугаар зүйлийн 16.5.1-т “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах” гэсэн заалтуудыг зөрчсөн.
3. 115.3 мянган төгрөгийн буцсан гүйлгээний дансны бичилтийг зардал бууруулж хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4.6-т “бүх зардал”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах”, 16 дугаар зүйлийн 16.5.1-т “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах” гэсэн заалтуудыг зөрчсөн.
4. НДШ-ийн өглөгийг санхүүгийн тайланд 3,764.8 мянган төгрөгөөр дутуу тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн.

5. НДШ-ийн тайланд албан хаагчийн цалинг 232.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах”, 16 дугаар зүйлийн 16.5.7-т “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэсэн заалтуудыг зөрчсөн.

6. Санхүүгийн үр дүнгийн цалин зардал болон олговол зохих цалинг 5,001.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах”, 16 дугаар зүйлийн 16.5.7-т “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэсэн заалтуудыг зөрчсөн.

7. Олговол зохих цалин болон ХХОАТ-ын цалин хөлсийг 2,231.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах”, 16 дугаар зүйлийн 16.5.7-т “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэсэн заалтуудыг зөрчсөн.

8. НДШ-ийн 139.6 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан

гаргах”, 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах”, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын Гуравдугаар бүлэг: Зардал дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Залруулаагүй алдаа:

Байхгүй

Нийт 2,023.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 1,452.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 571.6 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,023.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5,139.3 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Бүтэн жил ажилласан 4 албан хаагчийн цалингаас ХХОАТ-ын хөнгөлөлт тооцож суутгал хийгээгүйгээс 162.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.1-т “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалтуудыг зөрчсөн. УСНББОУС 1.27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.

3.1.2 Ээлжийн амралтын олговрыг цалинтай давхардуулан 292.6 мянган төгрөг илүү тооцож олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.1-т “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам” хавсралт 2 дугаар зүйлийн 2.2-т “Ажилтан ээлжийн амралтаа тухайн ажлын жилдээ багтаан хэсэгчлэн эдлэх бол хэсэгчлэн амрах ээлжийн амралтын аль нэг тасралтгүй амралтын хугацаа нь ажлын 10 өдрөөс доошгүй байна” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасныг тус тус зөрчсөн байна. УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.

3.1.3 Томилолтоор ажилласан үеийн унаа, хоолны хөнгөлөлтийг суутган тооцолгүй 6 албан хаагчид 117.0 мянган төгрөг давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.1-т “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам” хавсралтын 2 дугаар зүйлийн 2.6-т “Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчид томилолтоор ажиллуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр, батлагдсан зардлын төсвийг үндэслэн томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрийг урьдчилан олгоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасныг тус тус зөрчсөн байна. УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.

3.2 Албан шаардлага

3.2.1 Албан хаагчид цалингийн зардлаас хууль тогтоомжид заагаагүй 1,452.0 мянган төгрөгийн шагнал олгосон, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилал зөрчиж, зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “үр ашигтай байх”, 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудыг зөрчсөн. “УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой" заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн зардлаас хууль тогтоомжид заагаагүй шагналд олгохгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3.2.2 Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5-т заасныг зөрчин жилийн дундуур төлөвлөөгүй зардлыг нэмэгдүүлж МНБ-ийн нэмэгдлийг 2025 оны 6 сараас эхлэн 40%-иар буюу 25%-иар нэмэгдүүлэн тооцож, нийт 1,154.3 мянган төгрөг олгосон

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5-т “төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв

байх”, 17 дугаар зүйлийн 17.1.2-т “холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хянах”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтуудыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Жилийн дундуур төлөвлөөгүй зардал гаргахгүй байх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3.3. Зөвлөмж

3.3.1 Захиргаа, хуулийн тасгийн дарга З.Сумъяажавт доод түвшний албан тушаалын /нягтлан бодогчийн/ үүргийг түр орлон гүйцэтгүүлж, нягтлан бодогчийн цалингийн 40%-ийг олгосон нь хууль журамд нийцээгүй 2,081.8 мянган төгрөгийг олгосон

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.1-т “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3-т “энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх”, 43.6 “Энэ хуульд заасан журмыг зөрчиж, төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно,” Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.4-т “Төрийн албаны тухай хуулийн 3.1.4-т тодорхойлсон сул орон тооны албан үүргийг түр орлон гүйцэтгэх тохиолдолд тухайн албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг түр орлон гүйцэтгэсэн хугацаагаар тооцож олгоно. Албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн үндсэн цалин, сул орон тооны албан тушаалын үндсэн цалинтай адил буюу түүнээс бага байх тохиолдолд энэ журмын 2.2-т заасныг баримтална”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 17 дугаар зүйлийн 17.1.2-т “холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хянах”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтуудыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн зардлаас зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл: Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс		Зөвлөмж
				Залруулсан	Залруулаагүй	

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Говьсүмбэр аймгийн Татварын газар	8	12.3			8	12.3	8	12.3				
Дүн	8	12.3			8	12.3	8	12.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Үүнээс

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Говьсүмбэр аймгийн Татварын газар	8	5.3	3	0.6	2	2.6	1	2.1				
Дүн	8	5.3	3	0.6	2	2.6	1	2.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Тав.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
			Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

		Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	ОНӨҮГ								
3	Төсөл, хөтөлбөр								
4	ЗГТС								
5	ТТЗ								
6	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			